Овоотын Мэдээ

ХУРГАТАЙ ХАЙРХАН

2026.06 САР~№03 (25)

~Байгальд ээлтэй, Орон нутагт өгөөжтэй~

Мэдээллийг ил тод хүргэх нь

Хүний нөөц болон Худалдан авалтын баг хамтран орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн нээлттэй өдөрлөгийг уурхайн талбайд зохион байгуулахаар төлөвлөж байна.

► 2

Өнгөн хөрс хуулалт гэж юу вэ? Яагаад зайлшгүй шаардлагатай вэ?

Өнгөн хөрсийг хуулж, хадгалж, буцаан ашиглах нь газрыг “эвдэх” биш, харин түр хугацаанд ашиглаад дараа нь сэргээх боломжийг урьдчилан бүрдүүлж буй үйл явц юм.

► 3

Ажлын анкет илгээх болон нийлүүлэгчийн санд хэрхэн бүртгүүлэх вэ?

Иргэд болон байгууллагууд ажлын анкет илгээх, нийлүүлэгчээр бүртгүүлэх үйл явц, шаардлагатай бичиг баримт болон холбогдох сувгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү хэсгээс авна уу.

►4

Байгаль орчин

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан бүтээн байгуулалтын ажлууд

"Овоот" төсөл нь 2026 онд төслийн талбайд дэд бүтцийн барилга байгууламжийн инженерийн болон техникийн зураг төсөл боловсруулах, холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан батлуулах ажлууд үе шаттайгаар хэрэгжиж байна. Үүний зэрэгцээ дэд бүтцийн байгууламжуудын бэлтгэл ажлууд, талбайн зохион байгуулалт, хамгаалалтын хашаа барих, өнгөн хөрс хуулалт болон стандартын дагуу хадгалалт хамгаалалтын ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байна. Тухайлбал:

1. 2026 онд төслийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хоногт 200 м3 ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай Цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулан батлуулах, улмаар барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.
2. Усан хангамжийн дэд бүтцийн хүрээнд технологийн болон хурын ус хуримтлуулах зориулалттай 450,000 м3 хүртэл багтаамжтай усан сангийн далангийн инженерийн зураг төслийг боловсруулж, батлуулах ажил хийгдэнэ.
3. Барилга байгууламжийн төлөвлөлт, зураг төсөл баталгаажсанаар барилгын талбайн тодорхой хэсгүүдэд өнгөн хөрс хуулалт, хадгалалтын ажлууд хэрэгжихээр төлөвлөгдөж байна. Тус ажлууд нь зөвхөн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх бөгөөд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаатай холбоотой газар хөндөх ажил төслийн талбайн хэмжээнд хэрэгжихгүй болно.
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд төслийн дээрх үйл ажиллагаатай уялдуулж тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Редакцийн зурвас

Хэлсэндээ хүрэх алхмууд

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийг хэрэгжүүлэгч “Хургатай Хайрхан” ХХК нь орон нутагтай хамтран хөгжих, ил тод мэдээлэл хүргэх, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор “Овоот мэдээ” мэдээллийн сониныг тогтмол хүргэж байна.

Өмнөх хоёр дугаарт бид төслийн зорилго, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын талаар танилцуулсан. Харин энэ удаагийн дугаарт эдгээр амлалтууд хэрхэн бодит ажил болон хэрэгжиж эхэлж байгааг танилцуулж байна.

2026 онд “Овоот” төслийн хүрээнд уурхайн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд эхлэхээр төлөвлөгдөж байна. Үүнд ажилчдын кемп, засвар үйлчилгээний байгууламж, баяжуулах үйлдвэрийн барилгын бэлтгэл ажил, уурхайн талбайн дэд бүтцийн ажлууд багтаж байна.

Эдгээр бүтээн байгуулалтын ажлууд нь зөвхөн уурхайн дэд бүтцийг бүрдүүлэхээс гадна орон нутгийн ажил эрхлэлт болон бизнесийн хамтын ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Мөн энэ удаагийн дугаарт орон нутгийн иргэдийн сонирхдог гол асуудлуудын нэг болох уурхайн үйл ажиллагаатай холбоотой тоосжилтыг хэрхэн бууруулах талаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг онцлон танилцуулж байна.

Түүнчлэн төслийн мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх зорилгоор компанийн шинэ вэбсайтыг нээж, төслийн лицензийн талбай орчмын агаарын чанарын бодит цагийн мэдээллийг харах боломжтой LIVE dashboard-ийг олон нийтэд танилцуулж байна.



“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн 2026 оны төлөвлөлт

Дэлгэрэнгүй инженерийн зураг төсөл боловсруулж, улсын экспертиз болон зөвшөөрлийн үйл ажиллагааг дуусгасны дараа 2026 онд **бохир ус цэвэрлэх (цэвэршүүлэх) байгууламж** барихаар төлөвлөж байна.

Энэхүү байгууламж ашиглалтад орсноор талбай дээрх оффис болон кемпээс үүсэх ахуйн бохир усыг үндэсний стандартын шаардлагад нийцүүлэн бүрэн цэвэрлэх боломж бүрдэнэ.

Уул уурхайн лицензийн талбай дотор **ус хуримтлуулах далан (усан ан)-ийн барилгын** ажлыг 2026 ондоо багтаан эхлүүлж, 2027 оны хавар дуусгахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй инженерийн зураг төслийн тендерийн үйл ажиллагаа одоогоор явагдаж байна.

Үүний дараа барилгын ажил эхлэхээс өмнө улсын экспертиз болон зөвшөөрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэхүү далан нь хоёр үндсэн зориулалттай. Үүнд:

- **Хур тунадасны усыг хуримтлуулж уурхайн талбайн хэрэгцээнд ашиглах**
- **Нүүрс боловсруулах үйлдвэрийн** барилгын ажлыг дэлгэрэнгүй инженерийн зураг төсөл, экспертиз болон зөвшөөрлийн үйл ажиллагаа дууссаны дараа энэ зун эхлүүлэхээр төлөвлөж байна. Барилгын ажлыг үндэсний компаниар удирдуулан хэрэгжүүлнэ. Тус гүйцэтгэгч бэлтгэлээ хангаж 6 дугаар сард үндсэн ажлаа эхлэхээр төлөвлөгдөж байна.
- Нүүрс боловсруулах үйлдвэр, бохир ус цэвэрлэх байгууламж болон ус хуримтлуулах далангийн суурийн инженерийн зураг төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор геотехникийн судалгааны ажлууд одоогоор хийгдэж байна.
- Уурхайн дэд бүтцийн бүсийн эргэн тойронд **хашаа баригдана**. Энэхүү бүсэд нүүрс боловсруулах үйлдвэр болон бусад үйлдвэрлэлийн дэд бүтцийг ирэх

оны эцсээс өмнө барихаар төлөвлөсөн. Мөн уул уурхайн үйл ажиллагаа явагдах уурхайн бүсийн эргэн тойронд зуны хугацаанд нэмэлт хашаажуулалтын ажил хийгдэнэ. Энэхүү ажлыг орон нутгийн бизнесүүдтэй хамтран хэрэгжүүлэх нь бидний зорилго бөгөөд тус газрыг ашиглаж ирсэн малчидтай хамтарч ажиллана.

- Барилгын ажлууд эхлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулж, зохих журмын дагуу **хадгална.** Уурхайн бүсээс хөрс хуулалтын ажлыг 9 дүгээр сараас эхлүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд зориулсан шууд, байнгын ажлын байрны боломжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор уурхайн тоног төхөөрөмжийн операторын сургалтад туршлагагүй орон нутгийн иргэдийг хамруулах зорилгоор “Умардын уурхайчин” хөтөлбөрийг зуны хугацаанд дахин хэрэгжүүлэхээр зорьж байна.

Онцлох

Тоосжилтын менежмент – Хяналт, ил тод байдалд суурилсан хандлага



Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тоосжилтын асуудал нь орон нутгийн иргэдийн анхаарал татдаг чухал сэдвийн нэг билээ. “Хургатай Хайрхан” ХХК нь тоосжилтын асуудалд бодит, хэмжигдэхүйц, ил тод хандлагыг баримтлан ажиллахыг зорьж байна. Энэ хүрээнд:

- Тоосжилтоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах журмыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- Төслийн талбай болон орчны бүсэд агаарын чанарын хяналтын суурин станцуудыг байгуулна. Тус агаарын чанарын хэмжилтийн суурин багаж нь Oizom компанийн Polludrone Pro загвар бөгөөд нэгэн зэрэг PM2.5, PM10, PM100 ширхэгт тоос тоосонцор, дуу шуугиан, температур, чийгшил, даралт зэрэг үзүүлэлтийг бодит цагийн горимоор хэмжинэ.
- Хэмжилтийн үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлэх, ил тод нээлттэй ажиллана.
- Хяналтын мэдээллийг хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр тодорхой давтамжтай баталгаажуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн төслийн дэд бүтэц, инженерийн шийдлүүдийг тоосжилт үүсэх эрсдэлийг бууруулах, хязгаарлах зорилгоор тусгайлан төлөвлөсөн. Үүнд:

- Нүүрс боловсруулах болон тээвэрлэх үйл ажиллагааг битүүмж бүхий системээр зохион байгуулна. Мөн ачих буулгах үеийн хэсэгт шаардлагатай тохиолдолд усалгааны ажил хийгдэнэ.
- Шороон замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдны хязгаарын зохицуулалтыг мөрдүүлэх, олон салаа зам гаргахаас сэргийлэх, тогтсон нэг замаар зорчих хөдөлгөөнийг үйлдэнэ. Энэ нь тээврийн хэрэгслээс үүсэх тоосжилтыг тодорхой хэмжээнд бууруулах юм.

Уурхайн үйл ажиллагааны үед тодорхой хэмжээний тоос үүсэх боломжтой байдаг. Гэвч харагдаж буй тоосжилт нь заавал орчны бүсэд сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн үг биш юм. Бидний зорилго нь үүсэх боломжтой тоосжилтыг хамгийн бага түвшинд барих тодорхой орон зайн бүс дотор хязгаарлахад чиглэх болно. Мөн төслийн талбайн гаднах агаарын чанарын хяналтыг тогтсон цэгт тогтмол хийж орчны нөлөөллийг бодитоор үнэлнэ. Энэхүү мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байж иргэдийг бодит мэдээллээр хангах чухал ач холбогдолтой юм.

ОМ

Нээлттэй өдөрлөгийг зохион байгуулна

2026 онд “Хургатай Хайрхан” ХХК нь Хүний нөөц болон Худалдан авалтын баг хамтран орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн нээлттэй өдөрлөгийг Цэцэрлэг сумд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг ханган нийлүүлэгчээр оролцуулах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж буйгаараа онцлог юм. Түүнчлэн тус өдөрлөгөөр дамжуулан компанийн үйл ажиллагаа, төслийн явц, цаашдын төлөвлөгөөний талаар ил тод, нээлттэй мэдээллийг хүргэхийг зорьж байна.

Арга хэмжээний үеэр компанийн хүний нөөцийн бодлого, нээлттэй болон ирээдүйд бий болох ажлын байрны боломжууд, ажилд бүртгүүлэх үйл явц, шаардлага, шалгуурын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Мөн ханган нийлүүлэгчээр бүртгүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжүүдэд зориулан бүртгэлийн журам, шаардлага, хамтын ажиллагааны боломжуудын талаар нэгдсэн мэдээлэл өгнө.

Үүнээс гадна оролцогчид өөрсдийн сонирхсон чиглэлээр шууд зөвлөгөө авах, асуулт асуух, санал бодлоо солилцох боломжтой юм. Мөн орон нутгийн иргэд болон бизнес эрхлэгчдэд компанитай хэрхэн урт хугацаанд хамтран ажиллах, ажлын анкетыг хэрхэн зөв бөглөж илгээх, шаардлагатай бичиг баримтыг хэрхэн бүрдүүлэх, ханган нийлүүлэгчийн санд хэрхэн бүртгүүлэх зэрэг практик ач холбогдол бүхий мэдээллийг нэг дороос хүргэхийг зорьж байна.

Ингэснээр иргэд, байгууллагуудын оролцоо нэмэгдэж, орон нутгийн эдийн засаг болон ажиллах хүчний идэвхжилд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Энэхүү өдөрлөг нь зөвхөн мэдээлэл хүргэх төдийгүй орон нутагтай харилцан ойлголцлыг бэхжүүлэх, итгэлцлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бодитоор эхлүүлэх чухал алхам болох юм.

ОМ



Овоотын мэдээ сонин

Сонины зөвлөл:
Д.Ачит-Эрдэнэ
Ц.Батхүү
Г.Гүнбат

Дугаар эрхэлсэн:
Т.Маралгоо

Хэвлэлийн дизайнер:
Т.Маралгоо


Гэрэл зураг:
“Хургатай Хайрхан” ХХК

Хаяг:
Монгол Улс,
Улаанбаатар хот-15170, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-17, ЖиЖи цамхаг 9 давхар
Утас: +976 7011-6828

Email:
info@khurgataikhairkhan.mn

Website:
www.khurgataikhairkhan.mn

ӨНГӨН ХӨРС ХУУЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ, ЯАГААД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ВЭ?



Энэхүү зурагт хөрсний үе давхаргуудыг харуулсан бөгөөд хамгийн дээд хэсэгт байрлах өнгөн хөрс нь ургамал ургах, байгалийн тэнцвэр хадгалагдах хамгийн чухал давхарга юм. Уул уурхайн үйл ажиллагааны өмнө зөвхөн энэ давхаргыг стандартын дагуу хуулж, тусгайлан хадгалснаар дараа нь нөхөн сэргээлтийн үед буцаан ашиглах боломж бүрддэг.

Төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд компани байгаль орчны нэгжтэй байх бөгөөд тус ажилтнууд байгаль орчны хууль эрх зүйн шаардлага, байгаль орчинд хариуцлагатай үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй ажиллах бөгөөд Цэцэрлэг сумаас байгаль орчны 2 ажилтан ажиллана. Тус ажилтнууд нь төслийн талбайд шинээр газар хөндөхөөс өмнө холбогдох журмын дагуу ажиглалт судалгаа хийж, хуулах шимт хөрс зузааныг тогтоож, хуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

ӨНГӨН ХӨРСИЙГ ХАМГААЛАХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Газрын хамгийн дээд хэсэгт орших шимт хөрс буюу өнгөн хөрс нь байгаль орчны хувьд хамгийн “амьд” давхарга юм. Ургамал ургах, бичил биетүүд оршин тогтнох, хөрсний үржил шим хадгалагдах зэрэг бүхий л үйл явц энэ хэсэгт явагддаг. Энгийнээр хэлбэл, бидний харж буй өвс ногоо, ургамал, байгалийн ногоон бүрхэвч бүгд энэ нимгэн давхаргад тулгуурлан амьдардаг.

Сонирхолтой нь, байгальд ердөө 1 см өнгөн хөрс бүрэлдэхэд хэдэн арван жил шаардлагатай байдаг бол илүү зузаан шимт хөрс бүрэлдэхэд хэдэн зуун жил зарцуулагддаг. Тиймээс энэхүү давхаргыг хамгаална гэдэг нь байгалийн олон жилийн хуримтлагдсан үнэ цэнийг хадгалж байна гэсэн үг юм.

Уул уурхайн болон барилгын ажил эхлэхийн өмнө Монгол улсын “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт” стандартын дагуу хуулж, хадгална.

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд хийгдэж буй энэхүү ажил нь зурагт үзүүлсэнчлэн зөвхөн өнгөн хөрсний түвшинд хийгдэж, байгалийн үржил шимтэй давхаргыг бусад хөрснөөс ангилан хадгалах нөхцөлийг бүрдүүлж байна.

ТӨЛӨВЛӨЛТӨӨС ЭХЭЛДЭГ ХАРИУЦЛАГА

Өнгөн хөрсийг хуулж авах ажил нь газар дээр эхлэхээс өмнө нарийвчилсан судалгаа, төлөвлөлтөөс эхэлдэг. Хөрсний зузаан, бүтэц, тархалтыг тодорхойлж, ямар гүнд хүртэл хуулалт хийхийг мэргэжлийн түвшинд тогтоодог.
Энэ нь ажлыг илүү хяналттай, үр ашигтай гүйцэтгэхээс гадна байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн шийдэл юм.

ӨНГӨН ХӨРСИЙГ ЯАГААД ЗААВАЛ ХАДГАЛДАГ ВЭ?

Хуулсан өнгөн хөрсийг шууд хаяхгүй, харин тусгайлан хадгалдаг. Учир нь энэ хөрс нь ургамлын үр, бичил биет, органик бодис зэрэг амьдралын үндсэн нөөцийг агуулдаг.
Судалгаагаар нэг атга өнгөн хөрсөнд хүртэл сая сая бичил биет оршиж байдаг бөгөөд эдгээр нь хөрсний үржил шим, ургамлын өсөлтөд чухал нөлөөтэй. Иймээс өнгөн хөрсийг зөв хадгална гэдэг нь зөвхөн шороо хадгалж байгаа биш, харин бүхэл бүтэн “амьд орчин”-ыг хамгаалж байна гэсэн үг юм.
Өнгөн хөрсийг хадгалахдаа салхи, усны элэгдлээс хамгаалсан талбайд, тодорхой стандартын дагуу овоолж байршуулдаг. Мөн хөрсний чийг, бүтцийг хадгалахын тулд гадаргуу дээр нь ургамал ургуулах зэрэг арга хэмжээг ч авдаг.
Эдгээр нь хөрсний чанарыг урт хугацаанд хадгалж, дараа нь буцаан ашиглах боломжийг бүрдүүлдэг.

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮНДЭС СУУРЬ

Ашиглалтын дараа хадгалсан өнгөн хөрсийг буцаан дэвсэж, ургамалжилтыг сэргээдэг. Энэ нь тухайн газрыг байгалийн төлөвт нь ойртуулах хамгийн үр дүнтэй арга юм.
Жишээлбэл, өнгөн хөрсийг хадгалж ашигласан талбайд ургамалжилт илүү хурдан, жигд сэргэдэг нь олон улсын туршлагаар батлагдсан байдаг. Өөрөөр хэлбэл, өнөөдөр хийж буй өнгөн хөрс хуулалт нь ирээдүйн “ногоон сэргэлт”-ийн эхлэл юм.

БАЙГАЛИЙН “САН” БҮРДҮҮЛЖ БАЙНА

Өнгөн хөрсийг тусад нь хадгална гэдэг нь ирээдүйд ашиглах байгалийн үнэт нөөцийг бүрдүүлж байна гэсэн үг. Энэ сан нь нөхөн сэргээлтийн үед хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг.
Хэрэв ийм байдлаар хадгалахгүй бол тухайн газрыг сэргээхэд шаардлагатай шимт хөрсийг байгаль өөрөө дахин бий болгоход маш урт хугацаа шаардагдана.

ЭНГИЙНЭЭР ОЙЛГОВОЛ...

Хэрэв бид байшингийнхаа суурийг сайн тавьж чадвал чанартай байшин босдогийн адилаар өнгөн хөрсийг стандартын дагуу хариуцлагатайгаар хууль, хадгалж чадвал өнгөн хөрс нь газрын “суурь” гэж ойлгож болно. Түүнийг хамгаалж хадгалснаар тухайн газрыг ирээдүйд сэргээх боломж илүү баталгаатай болдог.

менежментийн чухал хэсэг юм.
“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд эдгээр ажлыг төлөвлөгөөтэй, хариуцлагатайгаар хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах бодит арга хэмжээг авч байна. Тухайлбал бид төслийн талбай газар ашиглалтын менежментийн хүрээнд шинээр газар хөндөх ашиглах, харилцааг хуульд нийцүүлж дотоод журам боловсруулсан. Тус журмаар хөндөж буй газрын байгаль орчны нөлөөллийг тодорхойлж, бүртгэл, мэдээллийн санг үүсгэж, газрын эвдрэлийг бага байлгах дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Цаашлаад ашиглах газар бүрийн өнгөн хөрс буюу шимт хөрсийг хуулах, овоолго үүсгэх хадгалах, ашиглах харилцааг дотоод журмаар зохицуулна. Тус журмаар шимт хөрс хуулалт, хадгалалт, чанарын хяналт, бүртгэл, мэдээллийн сан үүсгэж, уурхайн ашиглалтын үеийн болон хаалтын дараах нөхөн сэргээлтэд шимт хөрсийг үр ашигтай ашиглахаар төлөвлөж байна.

СТАНДАРТ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

Энэхүү ажлыг Монгол Улсын хууль, холбогдох стандарт (MNS 5916:2008)-ын дагуу гүйцэтгэж, шимт хөрсийг тусад нь хадгалж, дараа нь ашиглалтын үеийн болон хаалтын нөхөн сэргээлтийн үед буцаан ашиглана. Энэ нь газрын түр хугацааны ашиглалтыг хариуцлагатайгаар зохион байгуулж, ашиглалтын дараа тухайн газрыг сэргээх боломжийг бүрдүүлдэг, уурхайн газар ашиглалтын

ТОВЧХОНДОО

Өнгөн хөрсийг хуулж, хадгалж, буцаан ашиглах нь газрыг “эвдэх” биш, харин түр хугацаанд ашиглаад дараа нь сэргээх боломжийг урьдчилан бүрдүүлж буй үйл явц юм. Энэ нь байгалийн олон жилийн бүтээлийг хамгаалж, ирээдүйд сэргээх боломжийг өнөөдрөөс бий болгож буй хариуцлагатай, төлөвлөгөөт хандлага юм.

ОМ

Ажлын анкет илгээх болон нийлүүлэгчийн санд хэрхэн бүртгүүлэх вэ?

Биечлэн уулзаж мэдээллээ бүрдүүлж өгөх

Цэцэрлэг суманд байрлах “Хургатай Хайрхан” ХХК-ийн мэдээллийн төвд өөрийн биеэр ирж, холбогдох анкет болон бүртгэлийн материалыг бөглөн өгөх боломжтой. Ингэснээр таны мэдээлэл илүү бүрэн, үнэн зөв бүртгэгдэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга хийх, шууд харилцах давуу талтай.

- Ажлын байранд бүртгүүлэх иргэд нь ажлын байрны анкетыг бүрэн бөглөж, цээж зураг, иргэний үнэмлэхийн хуулбар, боловсрол болон мэргэжлийн үнэмлэх, сертификат зэрэг холбогдох бичиг баримтыг хамтад нь авч ирнэ үү.
- Өмнө нь ажилласан туршлага, ур чадварыг баталгаажуулах баримт бичиг, тодорхойлолт байвал хавсарган ирүүлэхийг зөвлөж байна.
- Орон нутгийн аж ахуйн нэгж, компани, ТББ, хоршоо, нөхөрлөлүүд нь нийлүүлэгчээр бүртгүүлэхдээ байгууллагын гэрчилгээ, үйл ажиллагааны чиглэл, танилцуулга, туршлагын мэдээллийг авч ирж бүртгүүлнэ үү.
- Мэдээллийн төв дээр мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, бүртгэлийн явцтай холбоотой асуултад хариулт авах боломжтой.

Цахимаар мэдээллээ илгээх

Та цаг хугацаа хэмнэх, алсаас бүртгүүлэх зорилгоор цахимаар мэдээллээ илгээх боломжтой. Энэ нь хурдан, хялбар бөгөөд хүссэн үедээ мэдээллээ илгээх давуу талтай.

- www.khurgataikhairkhan.mn вэбсайтад нэвтэрч “Ажил, мэргэжил” болон “Худалдан авалт” гэсэн хэсгүүдэд орж, холбогдох анкет, бүртгэлийн маягтыг бөглөн илгээнэ үү.
- Бүртгэлийн маягтыг бөглөхдөө мэдээллээ үнэн зөв, бүрэн оруулж, шаардлагатай бичиг баримтыг хавсаргах нь таны бүртгэлийг хурдан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.
- Хэрэв бүртгэлтэй холбоотой нэмэлт асуулт, тодруулга гарвал дараах цахим шуудангаар холбогдох боломжтой:
  - Хүний нөөцийн асуудлаар: **hr@khurgataikhairkhan.mn**
  - Худалдан авалт, нийлүүлэгчийн бүртгэлтэй холбоотой: **procurement@khurgataikhairkhan.mn**
- Цахимаар бүртгүүлсний дараа шаардлагатай тохиолдолд танайтай холбогдож нэмэлт мэдээлэл авах, дараагийн шатны мэдээллийг хүргэх болно.

Анхбаяр: Нутагтаа ажиллана гэдэг надад хамгийн чухал

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, тогтвортой орлоготой болгохыг зорин ажиллаж байна. Энэ удаад бид төслийн кемпэд тогоочоор ажиллаж буй орон нутгийн ажилтныг онцолж, түүний ажлын туршлага, сэтгэгдэл болон нутагтаа ажиллахын үнэ цэнийг хуваалцаж байна.



Та өмнө нь хаана, ямар чиглэлээр ажиллаж байсан бэ?

Би өмнө нь “Могойн гол” ХК-ийн уурхайд тогоочоор ажиллаж байсан. Тэнд ажиллах хугацаандаа уурхайн нөхцөлд олон хүний хоол үйлдвэрлэлийг зохион байгуулах, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх, цаг хугацаанд нь хоол бэлтгэх зэрэг тал дээр туршлага хуримтлуулсан. Ийм төрлийн орчинд ажиллахад зохион байгуулалт, хариуцлага чухал байдгийг ойлгосон.

“Овоот” төслийн багт нэгдсэн сэтгэгдэл ямар байна вэ?

“Овоот” төслийн багт нэгдэж байгаадаа баяртай байна. Ажлын орчин, зохион байгуулалт сайн санагдсан. Ялангуяа орон нутгийн иргэдийг ажилд авч байгаа нь бодит боломж болж байгааг анзаарсан. Миний хувьд өөрийн нутагтаа ажиллаж, тогтвортой орлоготой байх боломж бүрдэж байгаад сэтгэл хангалуун байна.

Орон нутагтаа ажиллах нь танд ямар ач холбогдолтой вэ?

Орон нутагтаа ажиллаж байгаа нь надад хамгийн чухал зүйлсийн нэг. Гэр бүл, ойр дотнын хүмүүстэйгээ ойр байх боломжтойгоос гадна нутагтаа ажиллаж, тогтвортой амьдрах нөхцөл бүрдэж байна. Мөн орон нутгийн иргэдэд ажлын байр бий болж байгаа нь бодит боломж болж байгааг өөрийн биеэр мэдэрч байна.

Кемпийн тогоочийн ажил юугаараа онцлог вэ?

Кемпийн тогоочийн ажил нь олон хүний хоолыг богино хугацаанд, чанартай бэлтгэх шаардлагатай байдаг онцлогтой. Мөн ажилчдын эрүүл мэнд, тэнцвэртэй хооллолтыг хангах нь чухал. Уурхайн орчинд ажиллаж байгаа хүмүүсийн ачаалал өндөр байдаг учраас хоол хүнс нь тэдний өдөр тутмын эрч хүчид шууд нөлөөлдөг гэж боддог.



Цаашид ажилдаа ямар зорилготой байна вэ?

Цаашид ажилдаа илүү туршлага хуримтлуулж, хоол үйлдвэрлэлийн чанарыг тогтвортой сайн түвшинд барихыг зорьж байна. Мөн хамт олонтойгоо ойлголцож, ажлаа чанартай гүйцэтгэх нь миний хувьд чухал. Урт хугацаанд орон нутагтаа тогтвортой ажиллахыг хүсэж байна.

Овоот төслийн шинэ вэбсайт удахгүй нээгдэнэ

“Хургатай Хайрхан” ХХК нь төслийн мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх зорилгоор компанийн албан ёсны вэбсайтыг шинээр нээж, Овоот төслийн талаарх мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.



Вэбсайтаар дамжуулан:

- Овоот төслийн ерөнхий мэдээлэл
- Төслийн явц, мэдээ мэдээлэл
- Байгаль орчны мониторинг
- Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа
- Орон нутгийн хамтын ажилалагааны мэдээлэл зэргийг авах боломжтой.

Ярилцлага: Орон нутгийн иргэд ба бизнесүүдийн оролцоо

Н.Пүрэвдорж: *Хариуцлагатай уул уурхайн зарчмаар үйл ажиллагаа явуулна*

Энэ удаад бид хамтран ажиллагч байгууллага болох “Наран Гүрт” ХХК-ийн Ерөнхий захирал Н.Пүрэвдоржтой ярилцаж, өнгөрсөн хугацааны хамтын ажиллагааны үр дүн, орон нутгийн эдийн засагт үзүүлж буй нөлөө болон цаашдын боломжийн талаар тодрууллаа.



Өнгөрсөн жил хэрэгжүүлсэн хамтын ажиллагааг Та хэрхэн дүгнэж байна вэ?

Өнгөрсөн жилийн хамтын ажиллагааг бид эергээр дүгнэж байна. Төслийн хэрэгжилт нь орон нутгийн бизнесүүдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын байр бий болгоход бодит хувь нэмэр оруулсан. Энэ нь орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх чухал алхам болсон гэж үзэж байна.

Өнгөрсөн жил хэрэгжүүлсэн хамтын ажиллагааг Та хэрхэн дүгнэж байна вэ?

Манай компанийн оролцоо нь орон нутгийн ажиллах хүчийг татан оролцуулах, нэмэлт орлого бий болгох боломжийг бүрдүүлсэн. Үүний зэрэгцээ орон нутгийн ханган нийлүүлэгчид, жижиг дунд бизнесүүдтэй хамтран ажилласнаар эдийн засгийн эргэлт нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн бизнесүүдийн оролцоо хэрхэн нэмэгдсэн бэ?

Төслийн хэрэгжилтийн явцад орон нутгийн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид илүү өргөнөөр оролцох боломж бүрдсэн. Энэ нь бизнесүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, тогтвортой хамтын ажиллагааны суурь тавигдахад чухал нөлөө үзүүлсэн.

Ажиллах хүчний хувьд ямар өөрчлөлтүүд гарсан бэ?

Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, ур чадварыг нь хөгжүүлэх боломж нэмэгдсэн. Ингэснээр ажиллах хүчний оролцоо идэвхжиж, тухайн бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтэд бодит ахиц гарч байна.

Цаашид энэхүү хамтын ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх боломжийг Та хэрхэн харж байна вэ?

Цаашид орон нутгийн иргэд, бизнесүүдийн оролцоог улам нэмэгдүүлэх, тогтвортой хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чиглэлд ажиллах боломж өндөр гэж харж байна. “Хургатай Хайрхан” ХХК-тай хамтран ажиллах нь орон нутгийн хөгжилд урт хугацаанд эерэг үр нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.


Та энэ төслийн орон нутагт үзүүлж буй ач холбогдлыг хэрхэн дүгнэж байна вэ?

“Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, бизнесүүдийн оролцоог идэвхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна. Энэ хүрээнд “Хургатай Хайрхан” ХХК-ийн хэрэгжүүлж буй ажлууд нь орон нутгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж байна. “Овоот”-ыг хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болгоно гэж байгаа нь таашаалтай байна.

Хамтын ажиллагаанаас бодитоор: Бид хамтдаа юу бүтээв?

Хамтын ажиллагааны хүрээнд цех, агуулах, оффисын хосолсон барилга барих, ажилчдын кемпийн цахилгаан хангамжийн угсралт, холболтын ажлууд амжилттай хэрэгжиж, төслийн дэд бүтэц шат дараатайгаар бүрдэж байна. Эдгээр ажлууд нь төслийн талбайд найдвартай, аюулгүй үйл ажиллагаа явуулах суурь нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ орон нутгийн бизнесүүдийн оролцоог бодитоор нэмэгдүүлж байна.

“Наран Гүрт” ХХК-ийн орон нутгаас бүрдүүлсэн ажилтнуудын тоо бариимтаас дурдвал:



- 74.4% Мөрөн хотоос **29 ажилтан**
- 15.4% Цэцэрлэг сумаас **6 ажилтан**
- 7.7% УБ хотоос **3 ажилтан**
- 2.6% Тариалан сумаас **1 ажилтан**

З.Батдорж: *Хүний нөөцийн олон талт бодлого бариимталдаг*

“Овоот” коксжих нүүрсний цогц төсөл хэрэгжихийн хэрээр Цэцэрлэг суманд үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдэд бодит боломжууд бий болж, орон нутгийн оролцоо улам идэвхжиж байна. Энэ удаад бид Цэцэрлэг сумд бүртгэлтэй “Гурван Марал Эрдэнэ” ХХК-ийн захирал З.Батдорж ярилцаж, төслийн нөлөөг орон нутгийн бизнесийн өнцгөөс хэрхэн мэдэрч байгаа талаар хуваалцлаа.



Танай компани орон нутагт суурилсан бизнесийн хувьд энэ төслөөс ямар боломжийг хамгийн ихээр мэдэрсэн бэ?

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьд “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь тогтвортой ажлын захиалга, урт хугацаанд хамтран ажиллах боломжийг нээж өгсөн. Ялангуяа “Хургатай Хайрхан” ХХК-тай хамтран ажилласнаар манай үйл ажиллагааг өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Цэцэрлэг сумын бизнесүүдийн оролцоо өмнөх жилүүдтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Сүүлийн үед “Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд орон нутгийн бизнесүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Илүү олон компаниуд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэх боломжтой болж, орон нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгааг харж байна.

Танай компанийн хувьд хүний нөөц, ажиллах хүчний тал дээр ямар өөрчлөлт гарсан бэ?

Бид орон нутгаас нийт 11 иргэдийг ажлын байраар ханган ажилласан байна. Мөн ажилтнуудын ур чадвар сайжирч, тогтвортой ажлын орчин бүрдэх нөхцөл сайжирсанд баяртай байна.

Орон нутгийн бизнесүүдийн чадавх, хамтын ажиллагааны орчинд ямар ахиц гарч байна вэ?

Компаниудын хоорондын уялдаа холбоо сайжирч, хамтран ажиллах соёл илүү төлөвшиж байна. Энэ нь орон нутгийн бизнесийн орчныг илүү идэвхтэй, өрсөлдөх чадвартай болгож байна.

Та энэ төслийн орон нутагт үзүүлж буй ач холбогдлыг хэрхэн дүгнэж байна вэ?

“Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, бизнесүүдийн оролцоог идэвхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна. Энэ хүрээнд “Хургатай Хайрхан” ХХК-ийн хэрэгжүүлж буй ажлууд нь орон нутгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж байна.

Та энэ төслийн орон нутагт үзүүлж буй ач холбогдлыг хэрхэн дүгнэж байна вэ?


“Овоот” төсөл нь зөвхөн уул уурхайн бүтээн байгуулалт бус, орон нутгийн иргэдийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн боломжийг өргөжүүлэх чиглэлд эерэг нөлөө үзүүлж буй томоохон санаачилга гэж боддог. Төслийн хүрээнд хэрэгжиж буй ажлууд нь бүс нутгийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ илүү хариуцлагатай, тогтвортой уул уурхайн жишгийг бүрдүүлэхэд анхаарч буй нь онцлохуйц санагддаг.



“Гурван Марал Эрдэнэ” ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд төмөр замын терминалын хамгаалалтын хашаа барих ажлыг амжилттай хэрэгжүүлж, төслийн дэд бүтцийн чухал хэсгийг бүрдүүллээ. Энэхүү ажил нь талбайн аюулгүй байдал, зохион байгуулалтыг хангахын зэрэгцээ орон нутгийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж, бодит үр дүн бий болгосон юм.

Танин мэдэхүй

Байгаль орчин: Усны нөөцийн хэрэглээ – ДАХИН АШИГЛАЛТ



Энэхүү зураг нь гадаргын болон газрын доорх усны тархац, байгалийн усны системийг дүрслэн харуулж байна.

Бид төслийн үйл ажиллагаанд ус ашиглахдаа тухайн системд нөлөөлөл багатай менежментийг хэрэгжүүлнэ.

Уул уурхайн төслүүдийн хувьд ус ашиглалтаас үүдэж орон нутгийн усан хангамж, гадаргын усны горимд хэрхэн нөлөөлөхийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, хяналт тавих түүнийг олон нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай байдаг.

Уул уурхайн салбар дахь усны хэрэглээ нь байгаль орчны хамгийн их анхаарал татдаг асуудлуудын нэг байдаг. “Хургатай Хайрхан” ХХК нь усны нөөцийг зохистой ашиглах, хяналт, хамгааллын чиглэлд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. Орон нутгийн иргэдийн зүгээс хамгийн ихээр тавигддаг асуултуудын нэг бол уурхайн үйл ажиллагаа Тэс голын усны нөөц буюу гадаргын усанд нөлөөлөх эсэх тухай асуудал юм.

Тухайн газар нутгийн геологийн нөхцөлөөс хамаарч гадаргын болон гүний ус хоорондоо ус агуулагч давхарга тусгаарлагдсан шаварлаг, ус нэвтрүүлэхгүй үе давхаргатай байдаг. “Овоот” төсөл нь технологийн хэрэгцээнд гүний ус ашиглах бөгөөд гадаргын усанд нөлөөлөлгүй төлөвлөлтийг хийж байна.

Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд гадаргын болон гүний усны хяналтыг орон нутгийн иргэд, төрийн байгууллагын оролцоотой хамтран гүйцэтгэж, мэдээллийг олон нийтэд нээлттэй тогтмол танилцуулан ажиллана.

Овоотын коксжих нүүрсний уурхайн гидрологийн судалгааны ажлыг Усны мэргэжлийн байгууллагаар 2012 онд хийлгэсэн байдаг. Тус гидрологийн судалгаа болон нэмэлт судалгааны ажлын үр дүнд үндэслэж Усны тухай хуулийн дагуу усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг Монгол улсын Усны нөөцийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төслийн тухайд гол ус ашиглах хэсэг нь Нүүрс баяжуулах үйлдвэр юм. Бидний үйлдвэрийн технологийг сонголтоор баяжуулах үйлдвэр нь ашигласан усны 94 хувийг дахин ашиглаж, зөвхөн 6 хувийг цэвэр усны эх үүсвэрээс нөхөн авах байдлаар төлөвлөсөн нь усны хэрэглээг бууруулах чухал шийдэл болж байна.

Мөн үйлдвэрийн технологийн усны хэрэгцээг уурхайн шүүрлийн ус болон хур тунадасны усаар хангах бөгөөд ус хуримтлуулах санг ашиглахаар төлөвлөсөн.

Иймд төслийн ус ашиглалт нь ихэнхдээ дахин ашиглалт болон дотоод эх үүсвэрт тулгуурлах бөгөөд гадна усны хэрэглээг харьцангуй бага түвшинд байлгах нөхцөлийг бүрдүүлж байна.

“Хургатай Хайрхан” ХХК нь Монгол Улсын усны тухай хууль болон байгаль орчны хамгааллын дүрэм журмыг чанд мөрдөн ажиллаж, усны нөөцийг хамгаалах, зөв зохистой ашиглах чиглэлд гидрогеологийн судалгаа, хяналт буюу мониторинг, ил тод мэдээллийн тогтолцоог хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хяналтын үр дүнг олон нийтэд тогтмол, нээлттэй мэдээлнэ.

Тухайлбал Уул уурхайн төслийн ус ашиглалттай холбоотой асуудалд хараат бус мониторинг болон ил тод тайлагнал нь орон нутгийн иргэдийн итгэлцэл, байгаль орчны хамгаалал, төслийн урт хугацааны тогтвортой ажиллагаанд хамгийн чухал хоёр тулгуур болдог.
Олон улсын сайн туршлагаар уул уурхайн усны менежментэд зөвхөн компанийн дотоод хяналт хангалтгүй гэж үздэг бөгөөд гуравдагч талын үнэлгээ, олон нийтэд нээлттэй мэдээлэл, хамтын оролцоотой хяналт шаардлагатай байдаг.

Хараат бус хяналт гэдэг нь уурхайн компанийн өөрийн тайлангаас гадна төрийн байгууллага, шинжлэх ухааны мэргэжлийн байгууллага, зөвлөх байгууллага, иргэдийн төлөөлөл зэрэг бие даасан этгээдүүд байгаль орчны үзүүлэлтүүдийг хянаж, үнэлж, баталгаажуулах үйл явц юм.

Тус хяналтын хэрэгжүүлснээр мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах, усны нөлөөллийг бодитоор үнэлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, маргаан, үл ойлголцлыг бууруулах юм.

Хяналтын хүрээнд гүний усны түвшин, ашигласан усны хэмжээ, дахин ашигласан усны хэмжээ, усны чанар, гадаргын усны урсцын өөрчлөлт, малчдын худгийн байдал, усны хүртээмж, иргэдийн санал гомдол зэрэг анхаарал хандуулан ажиллана. Хараат бус мониторинг бол итгэлцлийн механизм юм. Ил тод тайлагнал бол мэдээллийг нуух биш хуваалцах соёл юм. Энэ хараат бус хяналт, ил тод мэдээллийг хэрэгжсэнээр уул уурхайн төсөл, орон нутгийн иргэд, төрийн байгууллагын хооронд урт хугацааны ойлголцол бий болно.

Төслүүдийн хувьд усны нөөцийг шинжлэх ухааны, хэмнэлттэй, ил тод, хариуцлагатай ашиглах нь төслийн урт хугацааны амжилтыг тодорхойлох чухал хүчин зүйл болно.

Ус бол зөвхөн өнөөдрийн хэрэгцээ бус, ирээдүйн хойч үеийнхний амьдралын үндэс суурь юм. Иймээс байгаль орчны хамгаалал, усны нөөцийн тогтвортой ашиглалт нь “Овоот” төслийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байх болно.

ОМ

НИЙГМИЙН ХӨТӨЛБӨРҮҮД



Ногоон тэжээлийн хөтөлбөр

“Хургатай Хайрхан” ХХК нь 2022 оноос эхлэн ногоон тэжээл тариалж, орон нутгийн малчдад зах зээлийн үнээс хямд үнээр нийлүүлж байна.
2025 онд нийт 3,228 боодол ногоон тэжээлийг бэлтгэн, 2026 оны 2-р сараас эхлэн малчин өрхүүдэд нийлүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь зуд, хаврын хүндрэлтэй үеийг даван туулахад бодит дэмжлэг үзүүлэх зорилготой юм.
Мөн 2026 оноос уг хөтөлбөрийг орон нутгийн аж ахуйн нэгжид гэрээгээр хариуцуулж хэрэгжүүлнэ. Үүнийг дагаад орон нутагт ажлын байр бий болох боломж бүрдэж байна. Энэхүү санаачилга нь уул уурхай, уламжлалт мал аж ахуй болон газар тариаланг зохистой уялдуулан хөгжүүлэх боломжтойг харуулж байгаагаараа онцлог юм.

“Хургатай Хайрхан” ХХК нь орон нутгийн иргэдийн амьжиргаа, байгаль орчин, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чиглэлд хариуцлагатайгаар ажиллахыг зорьж байна.

Тэтгэлэгт хөтөлбөр

“Хургатай Хайрхан” ХХК нь орон нутгийн залуусын боловсролыг дэмжих зорилгоор тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2025–2026 оны хичээлийн жилийн хаврын улиралд нийт 20 оюутанд тэтгэлэг олгож, нийт 60 гаруй сая төгрөгийн сургалтын төлбөрийг сургуулиудад нь шилжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь сурлагын амжилт өндөр, идэвх санаачилгатай оюутнуудыг дэмжих зорилготой бөгөөд голч дүн 3.0-аас дээш оюутнууд хамрагдах боломжтой.
Тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын дунд энэ жил их, дээд сургуулиа амжилттай төгсөж буй залуус олон байна. Тэдний төгсөлтийн баярт оролцож, хөдөлмөр зүтгэлийг нь баяртайгаар хуваалцах боломж бидэнд тохиосон юм.



Төгсөгчид маань тэтгэлэгт хөтөлбөрийн талаар сэтгэгдлээ хуваалцахдаа боловсролын замналдаа үнэтэй дэмжлэг болсон тухайгаа онцолсон юм.



"Хургатай Хайрхан компаниас өмнөх хичээлийн жилд сургалтын төлбөрийн тэтгэлэг авсан. Энэ тэтгэлгийг аваад амжилттайгаар төгсөж байгаадаа маш их баяртай байна. Цаашдаа мэдээж сурч боловсорно, тэрнийхээ хажуугаар орон нутагтаа ихээхэн хувь нэмэр оруулж ажиллана гэж боддог.”

О.Үржинханд, АШУҮИС-ийн Хүний их эмчийн төгсөгч



"Оюутан болсон цагаасаа эхлэн дөрвөн жилийн турш энэхүү тэтгэлэгт хамрагдсан. Энэ нь миний сурч хөгжих хүсэл тэмүүлэлд үргэлж урам зориг, бодит дэмжлэг болж ирсэн. Ирээдүйд чадварлаг инженер болж, боломж гарвал төрөлх нутагтаа ажиллан хөгжлийнх нь төлөө хувь нэмрээ оруулахыг хүсдэг."

О.Батсуурь, ШУТИС, Цахилгаан системийн автоматжуулалтын төгсөгч

Сумандаа сайхан амьдаръя!

Бид орон нутагтаа тогтвортой хөгжлийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилгын хүрээнд ”Сумандаа сайхан амьдаръя” уриаг хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү ажлын хүрээнд аймаг, сумдад нэн шаардлагатай багш, эмч зэрэг мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг дэмжих зорилгоор тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Байгаль орчны манлайлал хөтөлбөр

Байгаль орчны асуудлыг олон нийтэд таниулж, залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Байгаль орчны манлайлал” хөтөлбөр 16 дахь жилдээ хэрэгжиж байна. Хөтөлбөрийн хүрээнд оролцогч залуус өөрсдийн санаачилсан жижиг төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд эдгээр нь мэдлэгийг бодит үйл ажиллагаа болгон хэрэгжүүлж буйг харуулж байна.



Спортыг дэмжих тогтвортой хөрөнгө оруулалт

"Хургатай Хайрхан" ХХК нь хүүхэд, залуучуудын эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, орон нутгийн тамирчдыг дэмжих, үндэсний спортын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд спортын олон төрлийн үйл ажиллагааг тогтмол дэмжин ажиллаж байна. 2026 оны 5, 6-р саруудад компанийн дэмжлэгтэйгээр дараах томоохон арга хэмжээнүүд амжилттай зохион байгуулагдлаа.

- Монгол Улсын Гавьяат тамирчин Д.Нармандахын нэрэмжит жудо бөхийн уламжлалт тэмцээн – 30 дахь жилдээ зохион байгуулагдаж, "Хургатай Хайрхан" ХХК гурав дахь жилдээ ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажиллав. Тэмцээнд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг, ОХУ болон Өвөр Монголоос ирсэн нийт 1700 гаруй тамирчин оролцлоо.



- “ТЭСИЙН ЭХИЙН ХҮЧТЭНҮҮД” улсын шилдэг бөхийн холбооны чуулга уулзалт, мялаалгын барилдаан – Цэцэрлэг суманд зохион байгуулагдаж, улс, аймаг, сумын цолтой бөхчүүдийн барилдаан, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх сургалт, соёлын арга хэмжээнүүдийг ивээн тэтгэн дэмжив.



- “Хоймор нутгийн ирээдүйн хүчтэн” өсвөрийн үндэсний бөхийн тэмцээн – Олон аймаг, байгууллагын өсвөрийн бөхчүүдийг нэгтгэсэн уламжлалт тэмцээнийг дэмжин ажиллаж, ирээдүйн тамирчдыг бэлтгэх, үндэсний бөхийн залгамж халааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулав.





Б.Хишигбат

Хөвсгөл аймгийн Өсвөрийн жудо шигшээ багийн дасгалжуулагч

“Тамирчдын амжилтын ард байгууллагын тогтвортой дэмжлэг хамгийн чухал байдаг. “Хургатай Хайрхан” компани сүүлийн жилүүдэд манай жудо бөхийн баг тамирчдыг тогтмол дэмжиж, улс, бүс, олон улсын тэмцээнд оролцох боломжийг бүрдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна”



Б.Хишигбат

Хөвсгөл аймгийн Өсвөрийн жудо шигшээ багийн дасгалжуулагч

“Хургатай Хайрхан” ХХК нь зөвхөн энэ удаагийн арга хэмжээг бус гар бөмбөг, бөхийн барилдаан зэрэг олон төрлийн спортын арга хэмжээг тогтмол дэмжиж ажилладаг нь сум орон нутгийн хэмжээнд томоохон хөрөнгө оруулалт болж байгаад талархаж байна.”



Н.Бямбасүрэн

Монгол Улсын бөхийн тайлбарлагч, Цэцэрлэг сумын бөхийн холбооны тэргүүн

“Жил болгон уламжлал болгон зохион байгуулдаг "Хургатай Хайрхан" компани ивээн тэтгээд энэ бол одоо монгол бөхийн хөгжил тэр дундаа Хөвсгөл аймгийн өсвөрийн залуучуудын бөхийн хөгжил бол маш өндөр хувь нэмэр оруулж байгаа ийм чанар чансаатай ийм сайхан барилдаан болж байна.”



Г.Батням

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын харьяат, аймгийн арслан

За ганцхан үндэсний бөх гэлтгүй жудо бөх, Хөвсгөл аймагт олон спортын үйл ажиллагаа, хүүхэд залуучууд руу харсан үйл ажиллагаа ингэж ивээн тэтгэж байгаа энэ сайхан компанийн хамт олонд баярлалаа. Шатрыг хүртэл хүн нүүгээд байвал сайн харагддаг. Бөхийг ч гэсэн ойр ойрхон барилдаад, ойр ойрхон бэлтгэл сургуулилт хийгээд байвал дадал зуршил болоод амжилт гаргах том хүнд суурь болдог. Тийм болохоор хүүхэд залуучууд руугаа харсан энэ барилдаанаа ойр ойрхон хийж байх нь илүү их ач холбогдолтой юм болов уу гэж би ингэж харж байгаа.

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ХАМТДАА

“Хургатай Хайрхан” ХХК нь “Овоот” төслийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн нийгэм, соёл, олон нийтийн үйл ажиллагааг дэмжихийг чухалчилж ажилладаг. Сүүлийн хугацаанд бид орон нутгийн байгууллага, арга хэмжээ, соёлын үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

Цэцэрлэг сумын Соёлын төвд хөгжим, техникийн хэрэгсэл хандивлалаа

“Хургатай Хайрхан” ХХК нь компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Соёлын төвд 20 сая төгрөгийн үнэ бүхий орчин үеийн хөгжим, техникийн хэрэгсэл хандивлалаа.

Энэхүү дэмжлэг нь орон нутгийн иргэдийнхээ соёл, урлагийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах, хүүхэд залуусын авьяас чадварыг хөгжүүлэх, үндэсний өв соёл, ёс уламжлалыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэж байна.



Цэцэрлэг сумын Соёлын төвийн дарга Ж.Азжаргал:



“Өмнө нь техникийн хүчин чадал жоохон дутагдалтай байсан. Одоо харин шинэ техник хэрэгсэлтэй болсноор Соёлын төв орчин үеийн мэргэжлийн дуу гаргалтын иж бүрэн чадал, яригч, нам давтамжийн яригч, тайзны монитортой болсноор соёл урлагийн арга хэмжээг техникийн өндөр түвшинд зохион байгуулах боломж бүрдэж байна. Чанартай техник хэрэгсэл нь хүүхэд, залуучууд, өөрсдийн авьяас чадварыг бодитоор мэдэрч, хөгжүүлэхэд том түлхэц болсон. Ялангуяа тайзны монитортой болсноор хүүхэд, залуучууд, ардын авьяастнууд тайзан дээр өөрийн дуу хоолой хөгжмийн хэмнэлийг мэргэжлийн түвшинд сонсож ур чадвараа ахиулах боломжтой болж байгаа юм. Мөн ОНСӨ-ийг залууст өвлүүлэх, тэднийг урлагт дуртай болгоход үнэтэй хувь нэмэр оруулж байна. Хамгийн гол өөрчлөлт бол дуугаралтын иж бүрдэл, хүчин чадал юм. Техникийн энэхүү шинэчлэл нь Соёлын төвийн үйл ажиллагааг мэргэжлийн стандартад ойртуулж буй чухал алхам юм. Хөдөө багуудад очиж ажиллахад зөөврийн техник хэрэгсэл дутмаг байсан бол одоо харин хөдөө багуудын малчдадаа хүрч үйлчлэхэд хялбар дөхөм болж байгаад баяртай байна. Бидний санал хүсэлтийг хүлээн авч хамтран ажилласан танай байгууллагын хамт олонд баярлалаа.”

Цэцэрлэг сумын тээвэрчдын холбоотой хамтран ажиллах чиглэлд уулзалт хийв

“Хургатай Хайрхан” ХХК-ийн төлөөлөл Цэцэрлэг сумын хүнд тээвэр, тээвэрчдийн холбооны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны боломжийн талаар санал солилцлоо.

Уулзалтын үеэр төслийн хүрээнд тээврийн үйлчилгээний хэрэгцээ, орон нутгийн тээвэрчдийг хамтран ажиллуулах боломж, аюулгүй ажиллагаа болон хамтын ажиллагааны зарчмуудын талаар мэдээлэл өгсөн юм.

Ийнхүү орон нутгийн тээвэрчидтэй хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, харилцан ойлголцлыг бэхжүүлэх чиглэлд энэхүү уулзалт чухал алхам боллоо.



Хөвсгөл аймгийн “Хөх сувд 2026” мөсний баярт дэмжлэг үзүүлэв

“Хургатай Хайрхан” ХХК нь Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Хөх сувд 2026” мөсний баярт санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

Тус баяр нь орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн аялал жуулчлалын онцлогийг сурталчлах, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.





Хөвсгөл аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Л.Батцэцэг

Энэ жилийн мөсний баярын онцлог юу байв?

Хөвсгөл аймагт жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Олон улсын” гэх тодотголтой хөх сувд мөсний наадам амжилттай зохион байгуулагдлаа. Урьд өмнө 2 өдөр л болдог байсан энэхүү наадмыг бид 2025 онд 10 өдрийн турш зохион байгуулж байсан бол энэ жил 3 өдөр зохион байгууллаа. Өмнө жилээс цөөн хоног зохион байгуулсан ч зорьж ирсэн аялагч, жуулчид, үзэгчдийн тоо сайн байсан, дотоод, гадаадын жуулчдын оролцоо нэмэгдэж, өвлийн аялал жуулчлалын идэвхжил илүү тодорхой мэдрэгдсэн. Мөн соёл, спортын төрлүүдийг хослуулсан олон арга хэмжээ зохион байгуулагдсанаар баярын агуулга илүү баяжиж, оролцогчдод шинэ туршлага олгосон гэж үзэж байна.

Ийм төрлийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх нь орон нутагт ямар ач холбогдолтой вэ?

Ийм төрлийн арга хэмжээг тогтвортой, өргөн хүрээнд зохион байгуулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж, баярыг илүү өргөн хүрээнд, зохион байгуулалт сайтай явуулахад дэмжлэг болж байгаад талархалтай байна.

“Хургатай Хайрхан” ХХК нь орон нутгаас зохион байгуулж байгаа томоохон эвент, үйл ажиллагаанд, тэр дундаа мөсний баярын арга хэмжээнд тогтмол дэмжлэг үзүүлж ирсэн. Энэ нь бидний зохион байгуулж байгаа арга хэмжээний цар хүрээг тэлэх, зохион байгуулалтыг сайжруулах, оролцогчдын авьяас, чадварыг дэмжихэд бодит нөлөө үзүүлж байна. Үүний зэрэгцээ аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, орон нутгийн бизнес, үйлчилгээний салбарын идэвхжилийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлж байна.

Хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэднийг соёл, спортын арга хэмжээнд идэвхтэй оролцох боломж бүрдүүлэхэд чиглэсэн ийм төрлийн санаачилгуудыг дэмжиж ирсэн “Хургатай Хайрхан” ХХК болон бусад байгууллагуудад талархал илэрхийлье.

Орон нутгийн иргэдийн оролцоо хэр байсан бэ?

Иргэдийн оролцоо өндөр байсан. Зөвхөн үзэгч хувьд биш, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрсдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр идэвх санаачилгатай байж, тэмцээн уралдаанд оролцон, орон нутгийн соёл, уламжлал, зан заншлыг түгээн дэлгэрүүлж байгаа нь онцлог байлаа.

Ялангуяа соёл урлаг, спортын уралдаан тэмцээнд хүүхэд, залуус, гэр бүлүүдийн оролцоо нэмэгдсэн нь анзаарагдсан. Иймарга хэмжээг тогтмол зохион байгуулах нь орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхээс гадна олон нийтийн уур амьсгалыг эергээр идэвхжүүлэх, нийгмийн харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Цаашид иймарга хэмжээг хэрхэн хөгжүүлэх боломжтой гэж харж байна вэ?

Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэн бэхжүүлж, ялангуяа хувийн хэвшлийн санал санаачилга, үүрэг оролцоог нэмэгдүүлэн, төр тэднийг дэмжих замаар олон төрлийн арга хэмжээг, илүү өргөн хүрээнд зохион байгуулах боломжтой гэж харж байна. Мөн олон улсын жуулчдыг татах, өвлийн аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байгаа.

Үүнээс гадна аялал жуулчлал төдийгүй бусад салбарын оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлд илүү анхаарах нь зүйтэй. Иймтөрлийн хамтын ажиллагаа нь урт хугацаанд орон нутгийн тогтвортой хөгжилд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.